

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН  
2022 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРӨӨС 9 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙГ  
ХҮРТЛЭХ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны 09 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн нийт байгууллага, хэлтэс нэгжийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 4661 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 4374, судлагдаж байгаа 217 өргөдөл хүсэлт байна. Хугацаа хэтэрсэн болон хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 64 өргөдөл хүсэлт байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 95,50 хувьтай байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 8 цаг 22 минут байна.

2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, өдөрт нь багтаан шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй, холбогдох файл хавсаргаагүй болон бусад 2767 зөрчил бүртгэгдсэн байна.

Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл:

1. Санхүү, татварын тухай-1616
2. Ажилд орох тухай-309
3. Ажлаас чөлөөлөгдөх тухай-266
4. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай-127
5. Газар чөлөөлөх тухай-97
6. Бусад-2246

Дээрх хугацаанд 2767 зөрчил бүртгэгдсэн байна. Эдгээр байгууллагуудыг нэрлэвэл:

1. Эрүүл мэндийн төв- нийт 297 өргөдлөөс 413 зөрчил
2. Татварын хэлтэс- нийт 1647 өргөдлөөс 226 зөрчил
3. Нэгдсэн эмнэлэг – нийт 74 өргөдлөөс 134 зөрчил
5. Улсын бүртгэлийн хэлтэс-нийт 55 өргөдлөөс 132 зөрчил
6. Газар зохион байгуулалтын алба нийт 281 өргөдлөөс 77 зөрчил
7. Цагдаагийн газар – нийт 103 өргөдлөөс 54 зөрчил
8. Бусад-1731 тус тус бүртгэгдсэн байна.

Эдгээр байгууллагуудад зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах чиглэл хүргүүлж өдөр тутамд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, албан хаагч нарт мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Мөн төрийн өмчийн сургууль цэцэрлэгүүдийн архив бичиг хэргийн ажилтнуудад Хариуцлагатай хандъя аяны хүрээнд Архив албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт сэдэвт сургалтыг зохион байгуулаад байна. Сургалтанд төрийн өмчийн 20 сургуулиас 18 нь, төрийн өмчийн 35 цэцэрлэгээс 32 нь хамрагдаад байна.

Засаг даргын Тамгын газраас Архив албан хэрэг хөтлөлт, [Egr.ulaanbaatar.mn](http://Egr.ulaanbaatar.mn) болон [edoc.ulaanbaatar.mn](http://edoc.ulaanbaatar.mn) системүүдийн ашиглалтыг сайжруулах үүднээс Хариуцлагатай хандъя аяныг 2022.04.01-ний өдрөөс 2022.06.30-ны өдрийг хугацаанд зарлаад байна.

Тус аяны хүрээд шинэчлэгдэн батлагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мөн өргөдөл гомдлын програмын

ашиглалтыг сайжруулах зорилгоор дүүргийн Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, албан хаагчдад батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгууллаа.

Өргөдөл гомдлын мэдээ тайланг улирал, сар болон тухай бүр гаргаж дээд шатны байгууллагад тайлагнан Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байгаа болно.

Дээрх хугацаанд 64 өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. Тодруулбал:

1. Татварын хэлтэс- 9
2. Цагдаагийн 1 дүгээр хэлтэс-6
3. Засаг даргын Тамгын газар-6
4. Эрүүл мэндийн төв-5
5. Цагдаагийн газар -4
6. Нийгмийн даатгалын хэлтэс-1
7. Цагдаагийн 2 дугаар хэлтэс-1
8. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс-1
9. Бусад байгууллага /Сургууль цэцэрлэг хороо байгууллага/-31 өргөдөл хүсэлт байна.

Дэргэдэх хэлтэс албадын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр болон тухай бүр гарган Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэвшээд байна.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2022 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРӨӨС 09 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ  
ӨДРИЙГ ХҮРТЛЭХ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 09 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 875 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 818, судлагдаж байгаа 51 хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 6 өргөдөл хүсэлт байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 94,17 хувьтай байна.

2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 1 цаг 38 минут байна.

Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон холдбогдох файл хавсаргаагүй гэх мэт 242 зөрчил бүртгэгдсэн байна.

Хэлтсүүдээр харуулбал:

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 110 өргөдлөөс 60 зөрчил

Хууль эрх зүйн хэлтэс 53 өргөдлөөс 17 зөрчил

Санхүү төрийн сангийн хэлтэс 3 өргөдлөөс 1 зөрчил

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс 36 өргөдлөөс 23 зөрчил

Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс 430 өргөдлөөс 104 зөрчил

Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс 94 өргөдлөөс 8 зөрчил


Нийгмийн хөгжлийн хэлтэс 142 өргөдлөөс 13 зөрчил

Архивын тасаг 11 өргөдлөөс 12 зөрчил

Цэргийн штаб 2 өргөдлөөс 13 зөрчил тус тус бүртгэгдсэн байна.

Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч нарт сануулан ажиллаж байна.

Хандалтаар нь авч үзвэл:



Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:  
Тохижилт нийтийн аж ахуйн чиглэлээр:

Тус хэлтэст 2022 оны 9 сарын байдлаар 338 иргэнээс өргөдөл гомдол санал хүсэлт ирүүлсэн байна.

Үүнээс 298 иргэний өргөдлийг ажлын 1-10 хоногийн хугацаанд шийдвэрлэж, 42 өргөдөл гомдол санал хүсэлтийг хуулийн хугацаанд судалж байна.

Шийдвэрлэлт 88,1% үзүүлэлттэй байна.

1. Хүрээлэн буй орчин тохижилт үйлчилгээтэй холбоотой 257 өргөдөл
2. Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай 49 өргөдөл
3. Барилга хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний тухай 10 өргөдөл
4. Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбооны тухай 15 өргөдөл
5. Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай 6 өргөдөл
6. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тухай 1 өргөдөл

1.Хүрээлэн буй орчин тохижилт үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол

2022 оны эхний 9 сарын байдлаар ил, задгай хог хаягдал, түүвэр хогийг цэвэрлэх иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 01 дүгээр сарын 29-ний өдөр, 3 дугаар сарын 19, 04 дүгээр сарын 23-ны өдрүүдэд нийт 3 удаагийн их цэвэрлэгээний ажил явагдаж давхардсан тоогоор 4215 аж ахуй нэгж байгууллага, 21648 иргэн оролцож нийт 864,5 тонн хог хаягдлыг цэвэрлэж тээвэрлээд байна.



2022 оны 01 дүгээр сард дүүргийн 1-20 дугаар хороодын айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог тээврийн нарийвчилсан хуваарийг Засаг даргын орлогчоор батлуулан Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, үйлчилгээний ажилд байнгын хяналт тавьж байна.

Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 3 байгууллагатай 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл “цэвэр цэмцгэр сүхбаатар дүүрэг” аяныг зохион байгуулж ажиллахаар удирдамж батлуулан 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байгууллагуудад танилцуулж тухайн өдрөөс эхлээд байна.


Тус аяны зорилго байгууллагуудын ажилтан албан хаагчдын идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх нийгмийн хариуцлагыг өндөрсгөх, тохижилт, ногоон байгууламж, бүтээн байгуулалт, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, ажлын шинэ санал санаачлагыг дэмжих, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх замаар иргэдтэй хамтарч ая тухтай, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг хангах юм.



**ХОГ ТЭЭВРИЙН ШӨНИЙН АЧИЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ** сэдэвт аяныг дүүргийн 1-11 дугаар хорооны нутаг дэвсгэр- Энх тайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Өглөөний гудамж, Олимпийн гудамж, Сөүлийн гудамж, Цэрэндоржийн гудамж, Их тойруу, Бага тойруугийн гудамж дагуу үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүд болон хог тээврийн байгууллагууд дунд 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл зохион байгуулахаар удирдамж батлуулан хог тээврийн байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Мөн тус хороодын иргэн аж ахуй нэгж байгууллагуудад дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, хорооны Ажлын алба, хог тээврийн байгууллагуудын төлөөлөлтэй хамтран аяны хэрэгжилтэд байнгын хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.



Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар дэвшил менежмент ААТ, Сүхбаатар тохижилт ХХК-тай хамтран хог тээврийн мэдээллийн санг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Arcgis, Qgis программууд дээр хийж гүйцэтгээд байна. Өнөөдрийн байдлаар Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК-иудын 2320 ширхэг хог тээврийн гэрээний мэдээлэл байна. Тус мэдээллээр хог тээврийн рейс тооцох, ААНБ-уудын байршил, хог хаягдлын орлого тооцох, гэрээний хугацаа дуусах хугацаа зэргийг тодорхойлоход илүү хялбар болж байгаа юм.



Долоо хоног бүрийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Бямба, Ням гаригт дүүргийн нутаг дэвсгэрийн хог тээвэрлэлт, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний хяналтыг дүүргийн Засаг даргын тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс мөн хог тээвэрлэгч байгууллагын хамтаар хяналт тавьж, илэсэн зөрчил дутагдал, зөрчлийг газар дээр нь шийдвэрлэн ажиллаж байна.



Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн ханган Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн үйлчилгээг тогтмол хийлгэн иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.

Хил хаагдсантай холбоотойгоор хог тээвэрлэгч байгууллагын машин техникийн сэлбэг хэрэгсэл олдоц муу, парк шинэчлэлт хийж 12 машин авахаар болсон боловч 12 дугаар сард нийлүүлэгдэхээр хүлээгдэж байгаа, иргэн аж ахуйн нэгж байгууллагаас авч байгаа хогны хураамж 2013 оны үнэ тарифаар байгаа учраас тээвэрлэгч байгууллагын ажилчдын цалин хөлс бага гэх шалтгаанаар ажилтан ажлаасаа гарах асуудал гарсан зэрэг шалтгаанаар хог тээвэрлэлт удааширсан.



Иргэдээс нохой муур устгуулах талаар ирсэн санал хүсэлтийг шийдвэрлэхэд Нийслэлийн Захирагчийн ажлын албатай нохой муур устгах гэрээ байгуулсан Базалт нэгдэл ХХК 2022 оны 08 дугаар сарын 27-ны өдөр, 9 дүгээр сарын 9-ны өдөр дүүргийн 9-20 дугаар хороонд нохой устгалын эрчимжүүлсэн ажлыг зохион байгуулж 849 нохой устгалаа.

2022 оны 1 дүгээр сараас эхлэн нохой устгалын ажил удаашралтай байгаа учир нь төсөв хүрэлцэхгүй байсан талаар мэдэгдсэн.

Иймээс базалт нэгдэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан Нийслэлийн захирагчийн ажлын албанд нохой устгалыг эрчимжүүлэх талаар албан тоотыг хүргүүлсэн.




УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АГЛАМД

Сүүлийн үед нөхөн үстэвэрийг өжиж хийдэггүй, илэрхийж өгсөн дуулины мэдээллийн дагуу өргө хэмжээг авахгүй хувиараа аглаж, бичигжлэлт үүдэн зэвсгийг эзлэн нөхөн илэрж бага нарын хүүхдүүд хэвдүүлэн тиглэр иргэдээс удаа дараа гомдол ирж байна. Иймд Баядал, нэгдэн ХХК-нд өнө тэглээр мэдэгдэж яаралтай өргө хэмжээг авч өгнө үү.

Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын Тамгын Газар  
Төрийн, Нийтийн Ажлын Хэлтэс  
Хуульч Дарга  
Тэмүүлэн Дэлгэр  
2022.07.18 12:59



Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай өргөдөл, гомдол ирсэн санал, хүсэлт гомдлыг шийдвэрлэхдээ дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай А/101 дүгээр захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан, өнгө үзэмж муутай, явган зорчигч болон авто машины хөдөлгөөнд саад учруулсан, үзэгдэх орчинг хязгаарласан 52 байршлын хайс хашлага буулгах ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж ажиллалаа.







Нийслэлийн шуурхай удирдлагын төв, Нийслэлийн замын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар ОНӨААТҮГ болон мэргэжлийн инженерийн байгууламж хариуцсан байгууллагад тухай бүр албан бичиг болон хариуцсан дуудлага хүлээн авах төвд дуудлага өгч засвар үйлчилгээнд хяналт тавин иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.

**НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
 Даргын газар, Засаг даргын Тамгын Газар  
 Улаанбаатар хот, 15102  
 Төмөрөө Замон, 2022 05 30 10 25

**СУХБААТАР ДҮҮРГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНД**

Тус дүүргийн 3 дугаар хороо, Орос 3 дугаар сургуулийн урд зэсэгт явган хүн аюулгүй зорчих боломжгүй байгаа талаар иргэд, оршин суугчдаас удаа дараа гомдол ирж байна.  
 Иймд тус зэсэгт газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллага өөрсдийн эзэмшлийн газар дээр хивша барьсан эсэх дээр хяналт тавьж явган иргэн стандартын шаардлага хангасан явган замвар зорчих боломжийг судалж хариу мэдэгдэнэ үү.

**НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
 Даргын газар, Засаг даргын Тамгын Газар  
 Улаанбаатар хот, 15102  
 Төмөрөө Замон, 2022 05 31 10 30

**ҮНДЭСНИЙ ОБЕЛ АМГАЛТЫН ХҮРЭЭЛЭН ХХК-Д**

Танай байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд автомашинтай ногоон байгууламж сүйтгээд тоос шороо босгоод байгаа талаар иргэдээс санал хүсэлт ирүүлж холбогдох байгууллагад уламжлал өгнө үү гэсэн өргөдөл ихээр ирж байна.  
 Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд үйлчлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллана уу.

**НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА**  
 Даргын газар, Засаг даргын Тамгын Газар  
 Улаанбаатар хот, 15102  
 Төмөрөө Замон, 2022 06 07 15 50

**НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ**

Тус дүүргийн 1 дүгээр хороонд Авто машины засвар, үйлчилгээний зориулалтаар газар эзэмшиж байгаа иргэн Д.Батзоригийн эзэмшлийн газар дээр байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх саналтай байна.

### 3. Барилга хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний тухай өргөдөл гомдол

Барилга хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний тухай ирсэн өргөдөл гомдлыг Газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцан холбогдох дээд шатны байгууллага болон дүүргийн газар зохион байгуулалтын алба, мэргэжлийн хяналтын хэлтэс болон инженерийн байгууламж хариуцсан мэргэжлийн байгууллагад хандан шийдвэрлүүлж иргэнд хариу өгч ажиллаж байна.

**НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА**  
 Даргын газар, Засаг даргын Тамгын Газар  
 Улаанбаатар хот, 15102  
 Төмөрөө Замон, 2022 06 07 13 52

**БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД**

Тус дүүргийн 8 дугаар хороонд Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар газар ашиглаж байгаа Шангри Ла Улаанбаатар ХХК-ны газар дээр байгаль орчны ерөнхий үнэлгээ хийлгэх саналтай байна.

**НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
 Даргын газар, Засаг даргын Тамгын Газар  
 Улаанбаатар хот, 15102  
 Төмөрөө Замон, 2022 06 30 10 25

**СУХБААТАР ДҮҮРГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНД**

Тус дүүргийн 3 дугаар хороо, Орос 3 дугаар сургуулийн урд зэсэгт явган хүн аюулгүй зорчих боломжгүй байгаа талаар иргэд, оршин суугчдаас удаа дараа гомдол ирж байна.  
 Иймд тус зэсэгт газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллага өөрсдийн эзэмшлийн газар дээр хивша барьсан эсэх дээр хяналт тавьж явган иргэн стандартын шаардлага хангасан явган замвар зорчих боломжийг судалж хариу мэдэгдэнэ үү.

**НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**  
 Даргын газар, Засаг даргын Тамгын Газар  
 Улаанбаатар хот, 15102  
 Төмөрөө Замон, 2022 06 20 11 31

**УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛТЫН ХӨРЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ БАГУУЛАЛТЫН ДЭХЛИХ ХӨТӨЛБӨР ТӨСВИЙД**

Тус дүүргийн 10 дугаар хороо 3 дугаар сургуулийн автобусны буудлын орчим танай байгууллагаас хэрэгжүүлсэн цэвэр, бохир усны шугам шинэчлэх төслийн хүрээнд явган замны нөхөн сэргээлтөөн ажил хийгдсэн.  
 Тухайн нөхөн сэргээлт хийгдсэн явган зам эвдэрсэн тул эвсвэрлэх өргө хэмжээ авч хариу мэдэгдэнэ үү.  
 Хэвсрэлтөөр одоо байгаа зургийг хүргүүлж байна.

Хэвсрэлт 4 зуурдастай

#### 4.Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбооны тухай өргөдөл гомдол

Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбоотой гомдлыг Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн эд хөрөнгийн тухай хуулийн дагуу газар дээр нь очиж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн ажилласан

Үүнд: -Хог тээвэрлэлт

-Гадна орчны цэвэрлэгээ, үйлчилгээ

-Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа

-Хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээ

Сууц өмчлөгчдийн холбоог татан буулгах, гүйцэтгэх захирал өөрчлөх талаар ирүүлсэн өргөдөл гаргагч иргэдтэй СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ хуулийн зүйл, заалт тус бүрийг танилцуулан оршин суугчдын бүх гишүүдийн хуралд хөндлөнгийн хяналт тавин оролцож мэдээлэл зөвлөмж өгч ажиллаж байна.



Хүнс худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Дүүргийн нутаг дэвсгэрт шинээр түргэн үйлчилгээний цэг нэмэгдэж буй шалтгаан:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/987 дугаар захирамжийн хүрээнд үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг бүртгэх, бүртгэлд хамрагдах үйлчилгээний жагсаалтад ТҮЦ орсон бөгөөд иргэд ямар ч зөвшөөрөлгүйгээр бүх чиглэлийн үйл ажиллагаа явуулж болно гэсэн ойлголтоор нийтийн эзэмшлийн зам талбайд дур мэдэн ТҮЦ байршуулж, үйл ажиллагаа явуулж байна.

1. Түргэн үйлчилгээний цэг болон худалдаа үйлчилгээ эрхлэхтэй холбоотой иргэдээс <https://erp.ulaanbaatar.mn> программын өргөдөл гомдлын цэсээр 2022 оны эхний 9 сарын байдлаар нийт 46 гомдол, хүсэлт ирснээс 40 өргөдлийг хуулийн хүрээнд шийдвэрлэн ажилласан.

2. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай А/596 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн чиглэл хүргүүлэх тухай 01/469 дүгээр албан бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн засаг даргын дэргэдэх “Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл” 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай сүүдрэвчтэй худалдаа эрхлэх байршлыг хорооноос ирсэн саналыг иргэдээс ирүүлсэн хүсэлттэй уялдуулан хороо тус бүрээр хэлэлцэн баталж, батлагдсан байршилд хүсэлт ирүүлсэн 12 худалдаа, 11 явуулын хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг гаргаж, хяналт тавин ажилласан.

3. НЗД-ын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай А/596 дугаар захирамжтай холбоотойгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүйгээр тавигдаж байгаа ТҮЦ, павильон эрс нэмэгдэж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны 8 сарын байдлаар 46 ТҮЦ шинээр нэмэгдсэн.

4. НИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34-р тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын 3.2-т Зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын захирамжаар батална гэж заасны дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай А/285 дугаар захирамж гарч, дүүргийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл байгуулагдсан. Зөвлөл 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж нийтийн эзэмшлийн зам талбайд тавигдсан иргэдийн зорчих хөдөлгөөнд саад учруулж байгаа, санал гомдол ихээр ирүүлж буй ТҮЦ-үүдийн газар чөлөөлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

4.1. Дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн Нийтийн эзэмшлийн зам, талбай, орц, гарц чөлөөлөх тухай А/312 дугаар захирамжийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдлын дагуу нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан нэн тэргүүнд нүүлгэх шаардлагатай 10 түргэн үйлчилгээний цэгт нийтийн эзэмшлийн газар чөлөөлөх албан шаардлагыг дүүргийн газар зохион байгуулалтын албанаас хүргүүлж, одоогоор 4 цэгийг албадан нүүлгэж, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлсөн.

4.2. Мөн дүүргийн Газар зохион байгуулалтын албанд 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам дээр шинээр тавигдсан, иргэдээс санал гомдол ихээр ирүүлж байгаа, нэн даруй нүүлгэх шаардлагатай 27 ТҮЦ-ийн газар чөлөөлөх 8/1572 дугаар албан бичгийг хүргүүлэн тухайн ТҮЦ-үүдэд албан шаардлага хүргүүлэн ажиллаж байна.

Нийгмийн хөгжил, хамгааллын чиглэлээр: Тус хэлтэст нь 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл <https://erp.ulaanbaatar.mn/> өргөдөл, гомдлын хэсгээр 129 өргөдөл, хүсэлт хүлээн авч шийдвэрлэж ажилласан. Үүнд:

№	Өргөдөлийн утга	Нийт ирсэн өргөдлийн тоо	Үүнээс	
			Хугацаандаа шийдвэрлэсэн	Хүлээгдэж байгаа
1.	Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай	35	35	
2.	Үрчлэлт тогтоох тухай	38	38	
3.	Буцалтгүй мөнгө, яаралтай тусламж, эмчилгээ, нийгмийн халамж хүссэн	16	11	5
4.	Гэр хүссэн	9	9	
5.	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний тухай	5	5	
6.	Асрамжийн газарт асруулах тухай	7	7	
7.	Орон сууцны хөтөлбөрт хамрагдах тухай	4	4	
8.	Боловсролын салбарын үйл ажиллагааны тухай	2	2	

9.	Хороодын үйл ажиллагааны тухай	2	2	
10.	Ажлаас чөлөөлөгдөх тухай	2	2	
11.	Хөдөлмөрийн харилцаа маргааны талаар зөвлөмж авах тухай	1	1	
12.	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тухай	1	1	
13.	Ажилд орох тухай	1	1	
14.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтийн тухай	1	1	
15.	Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны тухай	1	1	
16.	Хандивын мөнгө, мөнгө хураалтын тухай	1	1	
17.	Урлаг соёлын арга хэмжээний тухай	1	1	
18.	Биеийн тамир, спортын арга хэмжээний тухай	1	1	
19.	Дүрэмт хувцас, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний тухай	1	1	
20.	Нийт	129	124	6

Өргөдлийг шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулахад:

Үүнд:

№	Өргөдөлийн утга	Шийдвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл
1.	Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай 35	Иргэдээс ирүүлсэн 35 өргөдлийг хянаж үзэж, дүүргийн Засаг даргын 2022 оны Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох тухай А/01, 02, 09, 13, 14, 21, 22, 24, 32, 34, 83, 84, 85, 96, 112, 113, 127, 136, 137, 166, 169, 194, 202, 219, 230, 232, 233, 234, 235, 248, 276, 277, 284, 288, 310 дугаар захирамжуудыг гарган асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
2.	Үрчлэлт тогтоох тухай 38	Иргэдээс ирүүлсэн 38 өргөдлийг хянаж үзэж, дүүргийн Засаг даргын 2022 оны Хүүхэд үрчлүүлэх тухай А/06, 07, 08, 12, 23, 33, 35, 55, 78, 82, 95, 117, 118, 125, 126, 135, 164, 165, 168, 172, 182, 193, 203, 204, 215, 220, 222, 231, 244, 247, 259, 275, 290, 296, 297, 308, 309, 334, 340, 345, 346 дугаар захирамжуудыг гаргаж, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. <b>Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл.</b> Тайлбар: <a href="http://epg.ulaanbaatar.mn">epg.ulaanbaatar.mn</a> өргөдөл гомдлын программын Н220629006 дугаарын бүртгэлтэй тус дүүргийн 6-р хороо иргэн Г.Бямбадоржийн ирүүлсэн хүсэлт нь Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2. дахь хэсэгт үрчлүүлсэн хүүхдийг буцаан авахад иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах, үрчлэлтийг хүчингүйд тооцох шийдвэр гаргах заасны дагуу

		<p>боломжгүй тухай хариуг иргэн Г.Бямбадорж, С.Баттогтох нартай 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10:30 цагт уулзаж мэдэгдэв.</p>
3.	Гэр хүссэн 9	<ol style="list-style-type: none"> <li>1. Тус дүүргийн 16 дугаар хорооноос ирүүлсэн нөхцөл байдлын үнэлгээ, иргэний хүсэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2022 оны 05 сарын 19-ний өдрийн А191 дүгээр захирамжаар иргэн Э.Жаргалтуяад 5 сая 800 мянган төгрөгний өртөг бүхий 5 ханатай гэр олгосон.</li> <li>2. Тус дүүргийн 13 дугаар хорооноос ирүүлсэн нөхцөл байдлын үнэлгээ иргэний хүсэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2022 оны 05 сарын 19-ний өдрийн А190 дүгээр захирамжаар байшин нь шатсан иргэн Б.Болормаад 5 сая 800 мянган төгрөгний өртөг бүхий 5 ханатай гэр олгосон. Шийдвэрийг иргэн Б.Болормаад 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 03 цаг 40 минутад 99772138 утсаар мэдэгдэв.</li> <li>3. Тус дүүргийн 13 дугаар хорооноос ирүүлсэн нөхцөл байдлын үнэлгээ иргэний хүсэлтийг үндэслэн дүүргийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2022 оны 05 сарын 19-ний өдрийн А189 дүгээр захирамжаар иргэн Ц.Батхуягт 5 сая 800 мянган төгрөгний өртөг бүхий 5 ханатай гэр олгосон. Шийдвэрийг иргэн Ц.Батхуягт 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 16 цаг 30 минутад 98111026 утсаар мэдэгдэв.</li> <li>4. Б.Сүхбаатар нь дүүргийн 12 дугаар хороо хангайн 1-78 тоотод бүртгэлтэй боловч 2017 оноос хойш тухайн хаягт амьдраагүй, одоо налайх дүүрэгт амьдарч байна.Тус бүртгэлтэй хаягт аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулдаг. 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Б.Сүхбаатарын ээж Шүрэнцэцэгтэй 89865989 дугаарын утсаар холбогдож гэр хүссэн өргөдлийг шийдвэрлэх боломжгүй болохыг мэдэгдсэн.</li> <li>5. 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 15 цаг 20 минутад Т.Уламбаяртай 94788239 утсаар холбогдож, 2020 онд дүүргийн Засаг даргын захирамжаар 5 ханатай гэр олгосон тул дахин гэр, газар олгох боломжгүй болохыг мэдэгдлээ.</li> <li>6. Р.Цанжидтай 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 15 цаг 40 минутад 98108084 утсаар холбогдож, үндсэн хаяг болох дүүргийн 18-р хороо Бэлхийн 48-1646 тоотод оршин суудаггүй, (Баянзүрх дүүрэгт амьдардаг) гэрээ барих газаргүй, дүүргийн нутаг дэвсгэрт иргэнд шинээр өмчлүүлэх газар байхгүй тул хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй болохыг мэдэгдлээ.</li> <li>7. Иргэний хүсэлт, 17 дугаар хорооноос ирүүлсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн дүүргийн Засаг дарга гэр олгохоор шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрийг баталгаажуулах Засаг даргын зөвлөлийн хурлын тов хойшилсон тул захирамж түр хүлээгдэж буй болохыг</li> </ol>


		<p>иргэн А.Азжаргалд 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 20 минутад 86333677 утсаар мэдэгдэв.</p> <p>8. Тус дүүргийн 12 дугаар хорооны иргэн Ш.Шүрэнцэцэгийн амьдралын нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүүргийн Дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарны 08-ны өдрийн 4 дүгээр хурлаар хэлэлцүүлж, 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/236 дугаар захирамжаар 6 сая төгрөгний өртөг бүхий гэр олгохоор шийдвэрлэв. Иргэн Д.Шүрэнцэцэгтэй 89865989 утсаар ярьж, шийдвэрийг мэдэгдсэн.</p> <p>9. Дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/239 дүгээр захирамжаар тус дүүргийн 13 дугаар хорооны иргэн Г.Гэрэлцэцэгт 6,800,000 төгрөгийн өртөг бүхий 5 ханатай гэр олгов.</p> <div data-bbox="671 757 1449 965"> </div>
4.	Буцалтгүй мөнгө, яаралтай тусламж, эмчилгээ, нийгмийн халамж хүссэн 16	<p>1. Тус дүүргийн 5 дугаар хорооны иргэн Б.Сүхээд дүүргийн Засаг даргын 2022 оны 02 сарын 24-ний өдрийн А/52 дугаар захирамжаар эмчилгээ хийлгэхэд зориулан 1 сая төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгосон.</p> <p>2. Тус дүүргийн 3-р хорооны иргэн Б.Уртнасанд дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний А/53 дугаар захирамжаар эмчилгээ хийлгэхэд зориулан 1 сая төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэлээ.</p> <p>3. Дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/76 дугаар захирамжаар 11-р хорооны иргэн Ц.Цогзолмаад эмчилгээ хийлгэхэд зориулан 1 сая төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэлээ.</p> <p>4. Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/115 дугаар захирамжаар 12-р хорооны иргэн А.Ариунжаргалд амьдралын нөхцөл байдлыг үндэслэн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлээ.</p> <p>5. С.Мөнхтөрд 19 дүгээр хорооноос ирүүлсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн дүүргийн Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/116 дугаар захирамжаар эмчилгээ хийлгэхэд зориулан 1 сая төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэсэн тухай 99100320 утсаар мэдэгдэв.</p> <p>6. Тус дүүргийн 13-р хорооны иргэн Т.Оюунчимэгт 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Б/42 дугаар захирамжаар 5 сая 800 мянган төгрөгний өртөг бүхий</p>

		<p>5 ханатай гэр буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдвэрлэлээ.</p> <p>7. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/238 дугаар захирамжаар тус дүүргийн 16 дугаар хорооны иргэн Л.Уртнасанд эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж 5,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэлээ.</p> <p>8. Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/115 дугаар захирамжаар 12-р хорооны иргэн А.Ариунжаргалд 1 сая төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэв.</p> <p>9. Тус дүүргийн 14 дүгээр хорооны иргэн Баярмөнхийн Даваасүрэн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 18-ны өдрүүдэд Булган аймагт зохион байгуулагдах Монголын Үндэсний пара хөнгөн атлетикийн улсын аварга шалгаруулах тэмцээний Т-53, 54 тэргэнцэртэй 800,1500 метрийн зайн төрөлд дүүргээ төлөөлөн оролцох тул замын зардалд шаардагдах 340.000 (Гурван зуун дөчин мянган) төгрөгийг Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гаргахаар Дүүргийн Засаг даргын 2022 оны А/225 дугаар захирамжаар шийдвэрлэв.</p> <p>10. Тус дүүргийн 166 дугаар цэцэрлэгийн эрхлэгч С.Анхбаярын гэр бүлийн хүн хүнд өвчний улмаас гадаадад эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул эмчилгээний төлбөрт мөнгөн тусламж үзүүлэхийг хүссэн. Албан хаагчийн гаргасан хүсэлтийг цаасан суурьтай өргөдөл хэлбэрт оруулж, холбогдох эмнэлэгийн онош магадлагааг хавсарган файлаар хавсаргаж, дахин хандахыг мэдэгдэж хүсэлтийг буцаав.</p> <p>11. Сүхбаатарын талбайд 2022 оны 09 дүгээр сарын 16, 17, 18-нд зохион байгуулагдах “Номын баяр”-ын өдөрлөгт оролцож номоо борлуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>12-16 Эмчилгээний зардалд дэмжлэг хүссэн</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Дүүргийн ахмад ажилтан С.Рэнцэнханд,</li> <li>2. Газар зохион байгуулалтын албаны ажилтан Н.Мөнхтуяа,</li> <li>3. Газар зохион байгуулалтын албаны ажилтан О.Эрдэнэчимэг,</li> <li>4. мөнгөн дэмжлэг хүссэн 3 дугаар хорооны иргэн С.Отгонжаргал,</li> <li>5. 15 дугаар хорооны иргэн Д.Мөнгөнчимэг нарын өргөдлийг Засаг даргын зөвлөлийн хурлаа оруулж шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна.</li> </ol>
6.	Сургуулийн өмнөх боловсролын	<ol style="list-style-type: none"> <li>1. Тус дүүргийн орон тооны бус ёс зүйн зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар дүгнэлт, Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр</li> </ol>

үйлчилгээний тухай  
5

сарын 02-ны өдрийн Ц.Мягмарыг 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлаас чөлөөлөх тухай Б/55 дугаар захирамж нь холбогдох хуулийн дагуу гарсан захиргааны акт юм. Иймд таны гомдолд дурдсан дүүргийн Орон тооны бус ёс зүйн зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүчингүй болгож, албан хаагчдад хариуцлага тооцуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх боломжгүйг мэдэгдэж дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/368 дугаар албан бичгээр хариуг хүргүүлэв.

2. Тус дүүргийн 68 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б.Отгонтуяатай холбоотой гомдлын дагуу дүүргийн Орон тооны бус ёс зүйн зөвлөл 4 удаа хуралдаж, багш, ажилтнуудаас авсан санал асуулга, холбогдох баримтыг үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад



ажилтны дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн холбогдох ёс зүйн хэм хэмжээг Өзөрчсөнийг тогтоосон. Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн



Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай 33 дугаар тогтоолын хавсралтын 4.4 дэх хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны дагаж мөрдөх ёс зүйн дүрэм батлах тухай А/243 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 5.1 дэх хэсэг, дүүргийн Орон тооны бус ёс зүйн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн 68 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Батчулууны Отгонтуяаг 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн үндсэн цалинг гурван сарын хугацаагаар 20 хувиар бууруулах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах тухай дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн Б/56 дугаар захирамж гарсан.



3. Тус дүүргийн 11 дүгээр хорооны 546 дугаар байрны 705 тоотод оршин суугч иргэн Д.Сүрэнмандах








		<p>(ЙГ86072304)-ын хүсэлтийн дагуу дүү П.Бадамгарав (ЙГ16220120)-ыг цэцэрлэгтээ хамруулах боломжийг судалж хариу өгөх тухай 2022 оны 02 сарын 24-ний өдрийн 9/240 албан бичгээр Нийгмийн хөгжлийн хэлтсээс хүргүүлж, 24 дүгээр цэцэрлэгт хамруулсан.</p> <p>4. СБД-ийн, 19 дүгээр хорооны 283 дугаар цэцэрлэгт 24 цагийн бүлэг нээгдэж байгаа. Манайх 0-5 насны 3 хүүхэдтэй. Уг цэцэрлэгт хорооноос 12 хүүхдийн нэр өгсөн гэж байгаа бөгөөд манай хүүхдийг тус цэцэрлэгийн бүртгэлээс үндэслэлгүйгээр хассан байна. Манайх бүх шалгуур үзүүлэлтүүдийг хангачихсан байхад ямар ч үндэслэлгүйгээр хассанд гомдолтой байна. Тус 12 хүүхдийн нэрсэнд гурван өрхийн 6 хүүхэд орсон байгаа бөгөөд нэг өрхөөс 2 хүүхэд орсон байна. Уг асуудлаар тус цэцэрлэгтээ хандахаар хорооноос нэрс өгсөн гээд хариу өгсөн. Хороондоо очихоор танай хүүхэд тэнцэхгүй, цэцэрлэг нь мэдэж байгаа гэсэн хариуг өгөөд бие биедээ хандсан байдалтай байна. Уг асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Холбогдох харьяа байгууллагад нь уламжилж өгнө үү. гэсэн хүсэлтийн дагуу 283-р цэцэрлэгт 2 бүлгийг 24 цагийн үйл ажиллагаатай ажиллуулахаар төлөвлөн иргэдээс санал хүсэлт авч бүртгэл явуулсан байна. Хүсэлт гаргасан иргэдийн хүүхдийг хамруулах боломжтой тул өргөдөл гаргагчид хүсэлтээ ирүүлэхийг мэдэгдэж, тус цэцэрлэгт хамруулсан.</p> <p>5. СБД-ийн, 6-р хорооны 14-р цэцэрлэгийн хажууд барилга баригдаад тухайн цэцэрлэг ажиллахгүй гэж байна. Барилга баригдсанаас болоод хүүхдүүд хохирох юм уу? Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү. Гэсэн хүсэлтийн дагуу 14-р цэцэрлэгийн хажууд 16 давхар орон сууцны барилга баригдаж байгаа тул хүүхдийн аюулгүй байдлыг хангахаар тус цэцэрлэгт хүмүүжиж байсан 70 хүүхдийг 25-р цэцэрлэгт шилжүүлэн суралцуулахаар зохион байгуулалт хийгдсэн.</p>
6.	Асрамжийн газарт асруулах тухай 7	<p>1. Дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/10 дүгээр захирамжаар Ж.Батболдыг Ачлалт хүүхдүүд ТББ-ийн асрамжийн төвд асруулахаар шийдвэрлэсэн</p> <p>2. Дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний А/26 дугаар захирамжаар 8-р хорооны иргэн Н.Батжаргалыг Батсүмбэр дэх Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвд асруулахаар шийдвэрлэсэн</p> <p>3. Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/138 дугаар захирамжаар 5-р хорооны иргэн Л.Жанцандоржийг Төв аймгийн Батсүмбэр дэх Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвд асрамжийн газарт асруулахаар шийдвэрлэлээ.</p>

		<p>4. Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дүгээр сарын 24-ний өдрийн А/54 дүгээр захирамжаар Ш.Көкейханыг Батсүмбэр дэх Ахмад настны үндэсний төвд асруулахаар шийдвэрлэсэн</p> <p>5. Дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дүгээр сарын 11-ний өдрийн А/77 дүгээр захирамжаар 11 дүгээр хорооны иргэн Т.Баярцэцэгийг Кристина Ноблийн хүүхдийн сангийн “Нархан” төв асруулахаар шийдвэрлэсэн.</p> <p>6. Дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/265 дугаар захирамжаар 11 дүгээр хорооны иргэн Б.Сумъяадоржийг хөгжлийн бэрхшээлтэй хүний төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулан асруулахаар шийдвэрлэлээ. Өргөдлийг 2 удаа бүртгэгдсэн байна.</p>
7.	Орон сууцны хөтөлбөрт хамрагдах тухай 4	<p>1. Тус дүүргийн 19 дүгээр хорооны иргэн өндөр настан П.Цэрэндулам нь өөрийн гэсэн орон байргүй, охиныхоо гэрт амьдардаг тул орон сууцанд хамруулахыг хүссэн өргөдөл ирүүлсэн байна. Иргэн П.Цэрэндулам буцалтгүй мөнгөн тусламжид хамрагдсан тул гэр олгох боломжгүй болохыг мэдэгдлээ.</p> <p>2. Ахмадын орон сууцанд хамрагдах хүсэлт гаргасан Н.Батжаргалыг дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний А/26 дугаар захирамжаар улсын асрамжинд асруулахаар шийдвэрлэсэн.</p> <p>3. НҮНТ-ийн 1111 утсанд өргөдөл гаргасан 12 дугаар хорооны иргэн Ц.Чулуунбаатартай 88674880 дугаарын утсаар 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 11:22 минутад холбогдож, Нийслэлийн орон сууцны корпорацид хандан, түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ өгөх боломжтой талаар мэдээлэл, чиглэл өглөө.</p> <p>4. НҮНТ-ийн 1202 утсанд төрийн үйлчилгээний оператор ажилтанд өргөдөл гаргасан иргэн Ц.Чулуунбаатартай 91669093 дугаарын утсаар 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 08:50 минутад холбогдож, дүүргийн 11 дүгээр хороо Ногоон нуурын гудамж Про вон оффис 18 давхарт байрлах Нийслэлийн орон сууцны корпорацид хандан, түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ биеэр болон цахимаар гарган өгөх боломжтой талаар мэдээлэл, чиглэл өглөө.</p>
5.	Боловсролын салбарын үйл ажиллагааны тухай 2	<p>1. БСШУСайдын 2020 оны 201 дүгээр тушаалаар 9 дүгээр анги төгсөгчдөөс 10 дугаар ангид элсүүлэх сурагчдад хязгаар тогтоохгүй хүсэлтийн дагуу үргэлжлүүлэн суралцуулах үүргийн ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад өгсөн. Тус дүүргийн 11 дүгээр сургуулийн 9 дүгээр ангийн сурагч Х.Эрдэнэ-Очир 3 удаагийн математик, физикийн шалгалтын дунджаар 28,8%-ийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.</p>

		<p>2.</p>  <p>Цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах шаардлагын дагуу цэцэрлэгийн хашаанд багш, ажилтнуудын автомашиныг байрлуулахгүй байх үүрэг даалгаварыг цэцэрлэгийн эрхлэгч Т.Мөнхтуулд өгч хэрэгжилтийг ханган ажиллав. Цаашид гомдол гаргагчтай хамтран хяналт тавьж, ажиллахаар хэлэлцэв.</p>
3.	<p>Хороодын үйл ажиллагааны тухай 2</p>	<p>1. Биеийн тамир, спортын улсын хорооноос 2022 оныг иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнд уриалах, эртэч, идэвхтэй нийгмийг бий болгох, зорилтын хүрээнд 2022 оны 2 дугаар сарын 16-наас 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл орон даяар “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг эхлүүлж, 21 аймаг, есөн дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын спорт заал, танхимыг 06:30-07:30 цагийн хооронд үнэ төлбөргүй болгож, иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийг уриалж байна. Энэхүү ажлын хүрээнд уг арга хэмжээг зохион байгуулан ажиллаж буй тухайгаа өргөдөл гаргагчид мэдэгдэж, ойлголцолд хүрсэн.</p> <p>2. Тус дүүргийн ерөнхий боловсролын 16 дугаар сургууль нь 2244 хүүхэдтэй, 1 дүгээр ангийн анги дүүргэлт 46 сурагчтай, анги дүүргэлт ихэсч, 3 ээлжид орох төлөвтэй байна. Иймд 5 буудалд шинээр ашиглалтад орох 159 дүгээр сургуульд 12 дугаар хорооны 1 дүгээр ангид элсэн суралцах хүүхдүүдийг хамруулахаар хамран сургах тойргийн хуваарийг шинэчилсэн. Иргэдийн амьдралын зайлшгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж, суралцах сургуулийг сонгоход дүүргээс дэмжлэг үзүүлэн ажиллана. Мөн иргэд амьдрах орчин нөхцлөө сайжруулах хүсэлтээ Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгад /E-Mongolia, орон нутгийн хөгжлийн сан аппликэшн/ саналаа дэлгэрэнгүй өгөх боломжтойг мэдэгдсэн.</p> <p>3.</p>
4.	<p>Ажлаас чөлөөлөгдөх тухай 2</p>	<p>1. Тус дүүргийн Сүхбаатар дүүргийн 16 дугаар сургуулийн захирал О.Пүрэвжаргал нь эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдөх хүсэл гаргасан тул дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар</p> 

		<p>сарын 09-ний өдрийн Б/68 дугаар захирамжаар ажлаас чөлөөлсөн.</p> <p>2. Тус дүүргийн 24 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхцэцэг нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул албан үүргийг шилжүүлэх хүний нөөцийг асуудлууд хийгдэж байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Б/102 дугаар захирамжаар Д.Энхцэцэгийг өөрийн хүсэлтээр 24 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалаас чөлөөлж, Б.Баасанжаргалыг 24 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилов.</p>
5.	Хөдөлмөрийн харилцаа маргааны талаар зөвлөмж авах тухай 2	 <p>1. Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 3/471 тоот албан бичгээр Чингэлтэй дүүргийн иргэн Д.Болдбаатарт Зөвлөмж хүргүүлэх тухай албан бичгийг хүргүүллээ.</p>
6.	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тухай 1	1. Иргэн Ж.Соронзонд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 3/1556 тоот албан бичгээр хүсэлтийн хариуг хүргүүлэв.
2.	Ажилд орох тухай 1	Тус дүүргийн 143 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б.Анхмаад дүүргийн Засаг даргын 2021 оны 08 сарын 24-ний өдрийн Б/50 дугаар захирамжаар хүүхэд асрах чөлөө олгосон. Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3."жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах" заалтын дагуу ажилд орохыг хүссэн тул 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/116 дугаар захирамжаар албан тушаалд нь эргүүлэн томилсон.
3.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтийн тухай 1	 <p>Тус дүүргийн 11 дүгээр хорооны Хангай хотхон дахь шинээр баригдаж буй байрны тоглоомын талбай нь улсын комисст хүлээлгэж өгөөгүй тул нийтэд ашиглуулах боломжгүй талаар тайлбарыг иргэн Ц.Ариунжаргалтай 80004643 дугаарын утсаар холбогдон тухай үед мэдэгдэж байсан.</p>

		Одоогийн байдлаар тухай тоглоомын талбайг нийтэд ашиглуулж байна.
4.	Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны тухай 1	 <p>Иргэн Д.Дашжамцын өргөдлийг дүүргийн Ахмадын хорооны дарга Б.Мөнхцэцэгт танилцуулж, цаашид хамтран ажиллаж, санал санаачилгыг дэмжин хамтран ажиллахыг даалгасан. Энэхүү ажлын хүрээнд 2 дугаар хорооны ахмадын зөвлөлийн өдөрлөгийг 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр дүүргийн ахмадын хорооны ахмад хөгжлийн танхимд зохион байгуулж, 12 дугаар хорооны ахмад настан МУСТА морин хуурч, магтаалч н.Дашжамц, МУСТА шанзчин н.Сосорбурам, МУСТА ёочинчин н.Хандаа, ардын дуучин Цэндсүрэн нар уран бүтээлийнхээ дээжээс толилуулж хамтран ажилласан.</p>
5.	Урлаг соёлын арга хэмжээний тухай 1	 <p>Тус дүүргийн 10-р хорооны иргэн Ж.Нина, Д.Мижиддорж нарыг дүүргийн Засаг даргын Хүндэт Өргөмжлөл, 100 мянган төгрөгний мөнгөн шагналаар шагнасан. Шагналыг 10 дугаар хорооны Засаг даргын ажлын албаар дамжуулан гардуулсан.</p>
6.	Хандивын мөнгө, мөнгө хураалтын тухай 1	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 17-27-ны өдрүүдэд ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн захиралтай холбоотой гомдлыг шалгах Ажлын хэсэг байгуулан ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 06 сарын 17-27-ны өдрүүдэд 5 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгуулж шалгасан. Өргөдөлд дурдагдсан асуудлаар нотлох баримт, тайлбар зэргийг үндэслэн шалгаж, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлээгүй тухай дүүргийн Засаг даргад танилцуулсан. Гомдлыг дүүргийн Орон тооны бус ёс зүйн зөвлөлөөр авч хэлэлцүүлж, 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар дүгнэлт гаргасан. Дүгнэлтийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Б/127 дугаар захирамжаар 6 дугаар сургуулийн захирал Э.Түвшинсайханд хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан.</p>

7.	Биеийн тамир, спортын арга хэмжээний тухай 1	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 сарын 03-ны өдрийн А763 дугаар захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг Логарифм сургуулийн захирал Б.Одхойд утсаар мэдэгдэж, захирамжийн хуулбарыг хүргүүлсэн.</p> <p>Захирамжийн хэрэгжилтийг ханган сургуулийн биеийн тамирын талбайг аюулгүй байдлыг хангаж засварлан заавар, зөвлөмж байршуулж, 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс нээсэн.</p>  
8.	Дүрэмт хувцас, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний тухай 1	<p>Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор Ц.Балхаажавын бүтээл "Хүн хорвоогийн нэг хэлтэрхий Монгол" 100 ширхэг номыг худалдан авах хоёр сая таван зуун мянган төгрөгний санхүүжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/58 дугаар тушаалаар шийдвэрлэж, 3, 5, 12, 16 дугаар хороодын номын булангийн баяжилтад зориулан олгох ажлыг зохион байгуулсан.</p> 

Төрийн албан хаагчийн сахилга, ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол

№	Албан хаагчийн овог, нэр	Албан тушаал	Холбогдох гомдлын товч утга	Шийдвэрлэсэн байдал
1	А.Энх-Амгалан	12-р хорооны Нийгмийн ажилтан	Манай гэр бүл дөнгөж төрсөн нярай хүүхэд үрчилж авах гэж байгаа юм. Энэ асуудлаараа мэдээлэл авах гээд СБД-ийн 12 дугаар хорооны нийгмийн ажилтанд хандаж учир шалтгаанаа хэлэхэд "май энэний зургийг ав" гэж хэлээд сууж байна. Шинжилгээний бичиг, эрүүл мэндийн хуудсаа чамаас ав гэж байна гэж хэлэхэд надад байхгүй өрхийн эмнэлэг дээрээ оч гэж хэлсэн юм. Өрхийн эрүүл мэндийн төв дээр очиход хүлээн авах ажилтан нь "нийгмийн ажилтнаасаа аваач, энд байхгүй гэж байна" гэж маш хүнд суртал гаргаж байна. Маш гомдолтой байна. Маш яаралтай эдгээр ажилтнуудад арга хэмжээ авч өгнө үү.	Судалж байгаа
2	С.Ган-Эрдэнэ	Боловсролын асуудал	Манай гэр бүл дөнгөж төрсөн нярай хүүхэд үрчилж авах гэж байгаа юм. Энэ асуудлаараа мэдээлэл авах гээд СБД-	Судалж байгаа

		хариуцсан мэргэжилтэн	ийн засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй холбоо бариад орон нутгийн харьяанд байгаа нярай хүүхэд үрчилж авч байгаа юм, төрсний гэрчилгээ регистрийн дугаараа аваагүй байгаа бүртгэлээ хаана хийлгэх яаж шийдвэрлэх вэ гээд асуухад утас авсан ажилтан нь би мэдэхгүй гээд хүлээлгэж байгаад өөр ажилтан дуудаж яриулсан ба тэр ажилтан нь ямар ч ойлгомжгүй хариулт өгчхөөд "яасан гэнээ, ээж аав нь хаана байна, би чамд түрүүн хэлээ биз дээ" гээд гэх зэргээр маш бүдүүлэг ёс зүйгүй хандлаа. Энэ ажилтнаас болж тодорхой мэдээлэл авч чадалгүй цаг хугацаа алдаж байна. Холбогдох газарт нь уламжилж, яаралтай шийдвэрлэж өгнө үү.	
3	9-р хорооны албан хаагчид		Сүхбаатар дүүргийн бүх хорооны хэсгийн ахлагч нар болон халамжийн мэргэжилтэн нь нийлээд 15 ширхэг баримт бүрдүүлж ир гэж шаардсан. Миний бие Шаргалжуутын рашаан амралт сувиллын газарт 7.14-7.23-ны хооронд сувилуулсан. Ирээд мөнгөө буцаан авах гэтэл бүрдүүлсэн баримтыг дахин бүрдүүлж ир гээд 3 дахин явуулсан. Энэ мэтчилэн хүнд суртал гаргаж удаа дараа чирэгдүүлж байгаа. 9 дүгээр хорооны Засаг дарга болон улсын бүртгэлийн мэргэжилтэн 2 нь иймэрхүү байгууллагын соёл бий болгож байна. Биеийн хэлэмж нь иргэдийг доромжилсон, ялгаварлан гадуурхсан биеийн хэлэмж үзүүлсэн. Иргэний бүртгэлээ шилжүүлэхээр очиж заавар зөвлөгөө авах гэтэл албан хаагч нь толгойгоо ширвэж дохио үзүүлсэн бөгөөд үүдэнд заавар бйгаагаа биеийн хэлэмжээрээ үл тоосон байдалтай илэрхийлсэн. Миний нэр дээр хүнсний талоныг хорооны албан хаагчид 2012-2019 он хүртэл иргэн миний зөвшөөрөлгүйгээр ашиглаж байсан. \Нүүрсний мөнгө өгөхгүй байна гээд тэдгээр албан хаагчдыг /11-11/ төвд хандаж хэлж байсан. Улс төрийн шалтгаанаар хянан хавчиж эхэлсэн эдгээр албан хаагчид. 2022 оны 1 дүгээр сараас хойш тус хороо луу 20-с дээш удаа очиход Засаг даргатай 2 удаа тааралдсан. Уг албан хаагч нь ажлын байран дээрээ огт байдаггүй. Эдгээр албан хаагчдад нь маш тодорхой арга хэмжээ авч өгнө үү. Тус	9-р хорооны Халамжийн мэргэжилтэн нь иргэн Л.Очирхуягт хууль, журмын дагуу холбогдох материалыг бүрдүүлж ирэх шаардлага тавьсан бөгөөд түүний нэр дээр хүнсний талон ашигласан эсэх асуудал нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хамаарах асуудал байна. Мөн иргэн Л.Очирхуягаас тайлбар авах гэхэд ойлгомжгүй олон янзын зүйлүүдийг хольж ярьсан. 9-р хорооны албан хаагчдыг ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан эсэх нь тогтоох

			хороо руу олон дахин явснаас болж гам алдаж, нуруу руу хатгаж өвдөөд, татаад байгаа. Шаргалжуут рашаан сувиллынхаа эмчтэй холбогдоход ядарсны улмаас гам алдагдсан байна гэж хэлсэн. Иргэн миний хувьд гомдолтой байна.	боломжгүй тул гомдлыг хаав.
4	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв		Сүхбаатар дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн 11357074 гээд дугаар руу залгасан боловч огт авахгүй байна. Ажлын өдрөөр ажлын цагаар яагаад утсандаа хариулж болохгүй байна вэ? Холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн захирал Ц.Булган иргэн Д.Нанзалдулам тай утсаар холбогдож тухайн өдөр ажлын өрөөний утас авах боломжгүй байсан талаар тайлбар өгч, уучлалт гуйсан бөгөөд холбогдох үйлчилгээг үзүүлсэн болно. Өөр гомдол санал байхгүй гэсэн тул гомдлыг хаав.
5	Г.Даваацэцэг	17-р хорооны Засаг дарга	СБД-ийн 15-р хорооны Засаг дарга намчирхаж ажлаа явуулж байна. Манай хороонд эко 00 барих төсөл явсан. Гэтэл энэ талаар мэдэгдээгүй зарим айлд хийсэн байна. Шалгаж өгнө үү.	Иргэн Г.Чулуунтогтох нь эко жорлон барих төсөлд хамрагдсан, өөр гомдол, санал байхгүй гэсэн тул гомдлыг хаав.
6	Г.Амгалан	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга	СБД-ийн Засаг даргын тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Г.Амгалан нь хууль, дүрэм журмаа огт мэдэхгүй байна. Голын дагуу ажиллаж байгаа авто засварын газрууддаа арга хэмжээ авч өгөөч гэж гомдол гаргасны дагуу тухайн ажилтан нь надаас ямар нэртэй газар ажиллаад байна гэж асуусаар байгаад хэлүүллээ. Өөрсдөө олж мэдэх ёстой биз дээ. Иргэний асуудлыг шийдвэрлээд залгах ёстой байтал залгаж байцаах ёсгүй биз дээ. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.	Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт голын ай сав газар, бэлхийн зуслан орчимд үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байхгүй байх тул гомдлыг хаав. Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа



				явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэл болон шалгалтаар тогтоосон болно.
7	Г.Амгалан	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга	СБД-ийн Хүнс, худалдаа үйлчилгээний дарга Г.Амгаланд гомдолтой байна. Яаралтай түргэн тусламж 103-ийн явган хүний гарц дээр Ж.Уранчимэгт жимс зарах зөвшөөрөл эрх мэдлээ урвуулан зөвшөөрөл өгөөд байгаад гомдолтой байна. Явган хүний гарцтай нийтийн эзэмшлийн замд энэ хүн жимс зарах ёсгүй. Энэ асуудлыг шалгаж, шийдвэрлэж өгнө үү.	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга Г.Амгалан нь иргэн Ж.Уранчимэгт Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Яаралтай түргэн тусдамжийн 103 төвийн явган хүний гарцны орчимд худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоогүй байх тул гомдлыг хаав.
8	18-р хорооны албан хаагчид		СБД-ийн 18 дугаар хороотой, холбогдох утас байдаггүй. Байгаа хэдэн утас руу нь залгахаар огт утсаа авдаггүй.Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх хамгийн доод шатны байгууллага утсаа авахгүй байж болдог юм уу? Энэ асуудлыг холбогдох газар нь уламжилж өгнө үү.	Иргэн М.Ариунаанд 18-р хорооны Засаг дарга нь ээлжийн амралт авсан, Зохион байгуулагч байхгүй, Нийгмийн ажилтан ганцаараа ажиллаж байгаа нөхцөл байдлын талаар тайлбарлаж өгөв. Өөр гомдол санал байхгүй гэсэн тул гомдлыг хаав.
9	М.Өлзийбат	5-р хорооны Нийгмийн ажилтан	Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нийгмийн ажилтан нь хүний гомдол санал хүлээж авдаггүй, ямар ч мэдлэггүй иргэдийн төлөө гэсэн	Иргэн О.Чүлтэмсүрэн нь байнга согтууруулах

			сэтгэлгүй хүн байна. Ард иргэдэд тулгамдаад байгаа асуудлыг анхааралтай сонсож ойлгох, чин сэтгэлээсээ туслах сэтгэлгүй байгаад гомдолтой байна. Энэ асуудлыг холбогдох газар нь уламжилж өгнө үү.	ундаа хэрэглэсэн үедээ хорооны ажлын байранд ирж ажилтан, албан хаагчдыг загнаж, доромжилдог бөгөөд гаргасан гомдол болон тайлбарт тусгасан асуудал нь тодорхой бус байгаа тул гомдлыг хаав. Мөн өөрөө тухайн өдөр согтууруулах ундаа хэрэглэсэн байснаа хүлээн зөвшөөрсөн болно.
1 0	М.Мөнхзул	1-р хорооны Засаг дарга	СБД-ийн 1-р хорооны Засаг дарга н.Мөнхзул ажлаа хийхгүй, огт ажил дээрээ байдаггүй. Иргэдийнхээ санал хүсэлтийг сонсож, нөхцөл байдлаа ирж хардаггүй. Дандаа утсаар ажлаа явуулж байна. Утсаар хүн загнаад л зүгээр цалин аваад сууж байна. Энэ Засаг даргад гомдолтой байна. Арга хэмжээ авч, ажлыг нь хийлгүүлж өгнө үү.	1-р хорооны Засаг дарга М.Мөнхзул нь ажил дээрээ байдаггүй, ажлаа хийхгүй байна гэх гомдол нь хяналт шалгалтаар тогтоогдоогүй тул гомдлыг хаав.
1 1	Г.Амгалан	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга	СБД-ийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Г.Амгалан гомдолтой байна. СБД-ийн 1-р хороо, 103 яаралтай түргэн тусламж руу эргэдэг явган хүний зам дээр жимс зарж байгаа ямар ч зөвшөөрөлгүй хүнийг Ulaanbaatar.mn цахим хаягаар бүртгэлээ хийлгэж зөвшөөрөл авсан гэж худлаа өргөдлийн хариу өгсөн. Энэ асуудлыг шалгаж, иргэнд хариу өгнө үү.	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга Г.Амгалангийн иргэн Л.Лхамхүүд 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 8/701 дүгээр албан бичгээр хүргүүлсэн хариу нь үндэслэлгүй, худал болох нь тогтоогдоогүй

				тул гомдлыг хаав.
1 2	Л.Отгонцэцэг	7-р хорооны Засаг дарга	СБД-ийн 7-р хорооны засаг дарга н.Алтанцэцэгээс тодорхойлолт авах гэж ортол намайг хэл амаар доромжлоод тодорхойлолт хийж өгөхгүй байна. Би төрийн үйлчилгээ авах гэхээр энэ хүн иргэдэд үйлчлэхгүй байна. Чи энэ дүүрэгт амьдардаггүй гээд чамайг хорооноос хасна гэж сүрдүүлсэн. Тус хорооны засаг даргатай уулзахаар хэл амаар доромжилж, бие махбодод гэмтэл учруулсан намайг гүтгэж ёс зүйгүй үйлдэл гаргаж байгаад гомдол гаргаж байна. Тус хорооны дарга нь наад хүн чинь гар утсаар бичлэг хийсэн гэж гүтгэж цагдаа нарыг дуудаж битгий гарга гээд өөрийнхөө өрөөнд 30 минут хорьж, хэл амаар доромжилж загнаж суулгасан. Тус хорооны даргыг шалгаж, арга хэмжээ авч өгнө үү.	Иргэн А.Ариунзандан нь тус хороонд бүртгэлтэй боловч амьдардаггүй бөгөөд хууль бус үйлчилгээ авахыг шаардсаны улмаас маргаан үүссэн байна. Хорооны Л.Отгонцэцэг нь иргэн А.Ариунзандан г хэл амаар доромжилсон үйлдэл гаргаагүй байх тул гомдлыг хаав.
1 3	Ц.Амгалан	3-р хорооны Зохион байгуулагч	СБД-ийн 3-р хорооны оршин суугч байна. Манай нөхөр 2001 оны 11 сарын 28-ны өдөр нас барсан. Энэ хүний эмчлэх эрхийн хувьцааг авахаар хорооны зохион байгуулагч н.Амгаланд нас барсан гэрчилгээний хуулбар, өөрийн бичиг баримттай хамт үлдээсэн. Нотариатын ажилтан нь 2000 оны хүн амын тооллогын лавлагаа аваад ирээрэй гэсэн тул тус хорооны зохион байгуулагчид хэлсэн юм. Гэтэл тийм лавлагаа байхгүй гэж гээд намайг дахиж очиж уулзахад маш муухай харилцаж, загнасан. Тиймээс би өөрөө Үндэсний архивын газарт өөрөө очиж лавлагааг асуутал байж л байна. Төрийн албан хаагч ажлын байранд байхдаа хүнтэй харилцах харилцаа нойл байна хоёр дугаарт ажлаа мэдэхгүй байна. Би 38 жил төрөх эмнэлэгт эмчээр ажилласан төрийн байгууллагын ажлыг мэднэ. Ажлаа мэдэхгүй хүмүүст ингээд загнуулж байгаад гомдолтой байна. Холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, арга хэмжээ авч өгнө үү. Иргэнд тодорхой хариу өгнө үү.	Ц.Амгалан нь архиваас лавлагаа авах талаар холбогдох тайлбарыг өгсөн боловч иргэн нь тус хороог авч өгөхийг шаардсан нь хорооны гүйцэтгэх ажил биш тул зөрчилд тооцогдох үндэслэл байхгүй байна. Иргэнтэй зөв боловсон харьцаж байх талаар амаар сануулга өгсөн.
1 4	Д.Оюунбилэг	3-р хорооны Улсын бүртгэгч	СБД-ийн 3 хорооны 10 байрны 1 дүгээр орц 4 тоотод байр авсан юм. Байрны гэрчилгээ нь миний нэр дээр байгаа, нөхрөө байнгын оршин суугчаар	Улсын бүртгэгчтэй холбоотой гомдол байсан

			<p>бүртгүүлэх гээд очихоор өмнө нь авсан хүмүүс нь шилжигдээгүй гээд бүртгэж өгөхгүй байна. 2022 оны 04 дүгээр сарын 04ний өдөр хэрэглэгчдэд үйлчлэх төвд гэрээ хийх гээд очтол хорооны тодорхойлолт авч ирж байж гэрээ хийнэ гэсэн. Үйлчилж байгаа эмэгтэй харилцааны ёс зүйгүй, хүнд суртал ихтэй байгаад байна. Бичиг баримт бүх зүйл нь бүрдүүлээд ирэхээр ийм хариулт өгөөд байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжлан шийдвэрлэж өгнө үү.</p>	<p>бөгөөд гомдлын талаарх учрыг нь тайлбарлаж, Улсын бүртгэгчээс хаягийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үйлчилгээгээ авсан тул гомдлыг хаав.</p>
1 5	10-р хорооны албан хаагчид		<p>Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны төрийн байгууллагад ажиллаж байгаа чадваргүй ажилчдыг сольж өгөөч ээ. Бүгд нам дагасан хувийн ашиг сонирхлыг дээгүүр тавьсан хүмүүсийг сольж өгөхийг хүсэж байна. Төрийн албаны соёл байхгүй. Иргэн мэдээлэл авах гэж төрийн байгууллагад ороход бүгд ёс зүйгүй бүдүүлэг харьцдаг. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.</p>	<p>Дүүргийн 10 дугаар хорооны Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Б.Эрдэнэбулган болон бусад төрийн албан хаагчид холбогдох ямар нэгэн ёс зүй, сахилгын зөрчил гаргасан гэх тодорхой мэдээллийг гомдол гаргагч өгөөгүй тул зөрчил гаргасан нь тогтоогдоогүй болно. Тохижилтын ажилтай холбоотой хариу тайлбарыг 10 дугаар хорооны Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Б.Эрдэнэбулган болон Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс иргэн О.Сэлэнгэд өгсөн тул гомдлыг хаав.</p>
1 6	Д.Амаржаргал	5-р хорооны Засаг даргын үүрэг гүйцэтгэгч	<p>Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч н.Амаржаргалын харилцаа, хандлага, гаргасан үйлдэлд гомдол гаргаж байна. Улсын бүртгэгч нь</p>	<p>Иргэн Б.Цолмон, 5-р хорооны Засаг даргын үүрэг гүйцэтгэгч</p>

			сүлжээгүй эсвэл төв рүүгээ явсан тул өчигдрөөс хойш би асуудлаа шийдвэрлүүлж чадаагүй. Тус хорооны Засаг даргад хүсэлт тавихад хэл амаар доромжилж, ёс зүйгүй харилцсан. Миний гомдлыг шийдвэрлэж өгнө үү.	Д.Амаржаргал нарын хооронд үл ойлголцол гарч маргаан үүссэн бөгөөд Б.Цолмон үйлчилгээгээ авсан өөр гомдол санал байхгүй гэсэн тул гомдлыг хаав.
--	--	--	--	---

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчийн сахилга, ёс зүйтэй холбоотой нийт 16 гомдол ирсэн. 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар шийдвэрлэсэн 12, судалж байгаа 2 гомдол байна. Үүнээс Засаг даргын Тамгын 2 албан хаагчтай холбоотой 4, хорооны 10 албан хаагчтай холбоотой 10, дэргэдэх хэлтэс, албаны 2 албан хаагчтай холбоотой гомдол 2 байна.

Ирсэн гомдлыг хянан шалгахад төрийн захиргааны албан хаагчид хамааралтай 11, улс төрийн албан хаагчид хамааралтай 3 гомдол байх бөгөөд цуглуулсан тайлбар, баримт бичгээр албан хаагчийг сахилга, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй тул ёс зүйн болон сахилгын хариуцлага хүлээлгээгүй болно. Гомдолд холбогдох албан хаагчдад ажилдаа хариуцлагатай хандах, иргэдтэй зөв боловсон харьцахыг үүрэг болгосон.

Цаашид албан хаагчдыг сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын Дотоод журамтай танилцуулан, гарын үсэг зуруулан баталгаажуулж, хувийн хэрэгт хавсаргасан. Мөн бүх албан хаагчдад нэгдсэн удирдлагын [epg.ulaanbaatar.mn](http://epg.ulaanbaatar.mn) системээр болон шуурхай хурлаар иргэдтэй зөв боловсон харьцах, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, иргэдэд зөв мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгөх, ёс зүйн дүрэм, журмыг мөрдөж ажиллах талаар сануулга, анхааруулга, үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний хөгжлийн төвөөс зохион байгуулдаг Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албан хаагчийн манлайлал сэдэвт сургалтад 14 албан хаагчийг хамруулсан.

Төрийн албан хаагчийн сахилга, ёс зүйтэй холбоотой гомдлын ихэнх хувь гомдол гаргагчийн тухайн үеийн уур бухимдал, өөрийн хүссэн үйлчилгээг авахын тулд хууль бус шаардлага тавьсан, үл ойлголцол үүсч маргалдсан зэргээс үйдэлтэй байх тул гомдол хүлээн авч буй ажилтан нь тухайн асуудлыг сайн тодруулж бүртгэх нь зүйтэй байна.

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэст 2022.01.03-ны өдрөөс 2022.09.15-ны өдрийн хүртэл иргэнээс нийт 34 өргөдөл гомдол хүлээн авснаас 33-г шийдвэрлэсэн, 1 хуулийн хугацаанд судлагдаж байна.

Шийдвэрлэсэн хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлийн байдлыг үзвэл:

- 11 хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжилсан байна. Эдгээр нь ихэвчлэн Авто зам болон дахин төлөвлөлттэй холбоотой асуудлууд байна.
- 6 хүсэлтийг шийдвэрлэж, иргэнд хариу мэдэгдсэн.

- 6 хүсэлт шийдвэрлэх боломжгүй. Эдгээр нь ашиглалтын шаардлага хангахгүй, хөрөнгө оруулалт хийхийг хориглосон байранд засвар хийлгэх, иргэн аж ахуй нэгж байгууллагын эзэмших эрхтэй газарт хөрөнгө оруулалт хийх саналууд байгаа нь Төсвийн тухай хуулиар боломжгүй байна.
- 7 төслийг дараа оны хөрөнгө оруулалтын саналд хүлээн авсан. Төслийн судалгаа, холбогдох зөвшөөрлийг авч, зураг төсөв хийх, төсөвт батлах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь хугацаа шаардлагатай байдаг тул иргэнд шийдвэрлэсэн тухай хариуг шууд хүргүүлэх боломжгүй.
- 3 хүсэлтийн дагуу судалгаа хийж иргэнд зөвлөгөө чиглэл өгч ажилласан байна.

Дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дүүргийн харьяа төрийн байгууллагуудын дунд Хариуцлагатай хандъя аян зарлах тухай А/104 дүгээр захирамжийн дагуу аяныг 2022 оны 04 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд нийт 90 хоногийн хугацаанд амжилттай зохион байгуулаад байна.

Аяны хугацаанд ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Д/Д	Хамрагдсан байгууллага	Харьцуулалт	Хугацаа	
			2021 оны 04-06 сар	2022 оны 04-06 сар
1.	1-20 дугаар хороо	Нийт ирсэн өргөдөл	6	28
		Бүртгэгдсэн зөрчил зөрчил	30	53
		Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	21 хоног 20 цаг 4 минут	9 хоног 0 цаг 48 минут
		Шийдвэрлэлтийн хувь	100 хувь	89,29 хувь

Д/Д	Хамрагдсан байгууллага	Харьцуулалт	Хугацаа	
			2021 оны 04-06 сар	2022 оны 04-06 сар
1.	Дүүргийн харьяа хэлтэс албад	Нийт ирсэн өргөдөл	828	1114
		Бүртгэгдсэн зөрчил зөрчил	365	53
		Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	9 хоног 20 цаг 38 минут	8 хоног 14 цаг 19 минут
		Шийдвэрлэлтийн хувь	89,37 хувь	93,36 хувь

Д/д	Хамрагдсан байгууллага	Харьцуулалт	Хугацаа	
			2021 оны 04-06 сар	2022 оны 04-06 сар
1.	Дүүргийн төрийн өмчийн сургууль	Нийт ирсэн өргөдөл	2	64
		Бүртгэгдсэн зөрчил зөрчил	0	1
		Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	3 хоног 0 цаг 2 минут	4 хоног 21 цаг 26 минут
		Шийдвэрлэлтийн хувь	100 хувь	98,44 хувь

Д/д	Хамрагдсан байгууллага	Харьцуулалт	Хугацаа	
			2021 оны 04-06 сар	2022 оны 04-06 сар
1.	Дүүргийн төрийн өмчийн цэцэрлэг	Нийт ирсэн өргөдөл	0	171
		Бүртгэгдсэн зөрчил зөрчил	0	200
		Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	0 хоног 0 цаг 0 минут	4 хоног 14 цаг 37 минут
		Шийдвэрлэлтийн хувь	0 хувь	97,66 хувь

Зөрчил ихээр бүртгэгдсэн байгууллагуудыг нэрлэвэл:

Д/д	Байгууллагын нэр	Зөрчил	Тоо
1.	Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	92
2.	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	66
3.	Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын алба	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	59
4.	Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	53

5.	Сүхбаатар дүүргийн дүгээр хороо	19	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	12
6.	Сүхбаатар дүүргийн дугаар хороо	17	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	7
7.	Сүхбаатар дүүргийн дугаар сургууль	35	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	11
8.	Сүхбаатар дүүргийн дүгээр цэцэрлэг	234	Бүртгэгдсэн зөрчил (Автомат ажилбар)	56

Аянд амжилттай оролцсон байгууллагуудыг нэрлэвэл :

- Сүхбаатар дүүргийн Дэвшил ОНӨААТҮГ
- Сүхбаатар дүүргийн 4, 14 дүгээр хороо
- Сүхбаатар дүүргийн 131дүгээр сургууль
- Сүхбаатар дүүргийн 135, 51 дүгээр цэцэрлэг

Хариуцлага тооцох санал:

Хэлтэс нэгж, хороодын албан хаагчид ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, огт шийдвэрлээгүй, баримт бичгийн стандартын шаардлага хангаагүй, үг үсгийн болон найруулгын алдаатай баримт бичгийг хянаж зөвшөөрсөн, зөрчил гаргасан бол тухайн байгууллага холбогдох журмын дагуу дотооддоо арга хэмжээг авч ажиллана.

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

В.ГОМБОДОРЖ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЧИМЭДДУЛАМ



## ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН ТАЙЛАН

2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Дүүргийн Засаг дарга Х.Болормаа 7 хоног бүрийн мягмар гаригт иргэдийг хүлээн авч уулзаж байна. 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны хооронд 237 иргэнийг хүлээн авч уулзан санал бодлоо солилцов. Иргэдийн санал хүсэлтийг дурьдвал:

1. Газрын маргаантай асуудал
2. Газар чөлөөлөхтэй холбоотой
3. Ажлын хэргийн санал
4. Хувийн чанартай асуудал
5. Гэр хүссэн
6. Мөнгөн тусламж хүссэн
7. Эмчилгээний төлбөрт дэмжлэг хүссэн
8. Бусад

гэх мэт асуудлуудаар хандсан байна.

Эдгээрээс 124 хүсэлтийг өргөдлөөр хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлээд байна.

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



В.ГОМБОДОРЖ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЧИМЭДДУЛАМ

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХЭЛТЭС, НЭГЖҮҮДЭЭС ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ  
САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 09 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх ажил	Биелэлт
1.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч еgr.ulaanbaatar.mn нэгдсэн системд бүртгэх, өдөрт нь багтаан хүлээн авч, шилжүүлэх .	Нэр хаяг тодорхой өргөдөл гомдлыг иргэний мэдээллийн хамт хүлээж авах, бүртгэх шилжүүлэх.	<p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 875 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 818, судлагдаж байгаа 51 хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 6 өргөдөл хүсэлт байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 94,17 хувьтай байна.</p> <p>2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 1 цаг 38 минут байна.</p> <p>Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон холдбогдох файл хавсаргаагүй гэх мэт 242 зөрчил бүртгэгдсэн байна.</p>

		<p>Өргөдөл гомдлыг хүлээн авсан тохиолдолд иргэнд мэдэгдэх</p> <p>Өргөдөл гомдлоо шийдвэрлэсэн тохиолдолд иргэнд мэдэгдэж ямар нэг байдлаар заавал хариу өгсөн байх.</p>	<p>Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч нарт сануулан ажиллаж байна.</p>
<p>2.</p>	<p>Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж өргөдөл гомдлыг хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажиллах.</p>	<p>Байгууллага албан тушаалтанд улирал бүр чиглэл хүргүүлэх, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажиллах.</p>	<p>Өргөдөл гомдлыг өдөртөө багтаан хүлээн авч, хүлээн авсан, шийдвэрлэсэн тухайгаа иргэнд мэдэгдэж, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь нэг мөр болгон эцэслэн шийдвэрлэх явцыг мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>UB ERP программын ашиглалтыг сайжруулах үүднээс дэргэдэх хэлтэс албадад чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Мөн өдөр тутамд зөвлөгөө өгч байна.</p> <p>Засаг даргын Тамгын газраас Архив албан хэрэг хөтлөлт, Egr.ulaanbaatar.mn болон edoc.ulaanbaatar.mn системүүдийн ашиглалтыг сайжруулах үүднээс Хариуцлагатай хандъя аяныг 2022.04.01-ний өдрөөс 2022.06.30-ны өдрийг хугацаанд амжилттай зохион байгуулаад байна</p> <p>Тус аяны хүрээд шинэчлэгдэн батлагдсан архив, албан хэрэг</p>

			<p>хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мөн өргөдөл гомдлын програмын ашиглалтыг сайжруулах зорилгоор дүүргийн Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, албан хаагчдад батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Мөн төрийн өмчийн сургууль цэцэрлэгүүдийн архив бичиг хэргийн ажилтнуудад Хариуцлагатай хандъя аяны хүрээнд Архив албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт сэдэвт сургалтыг зохион байгуулаад байна. Сургалтанд төрийн өмчийн 20 сургуулиас 18 нь, төрийн өмчийн 35 цэцэрлэгээс 32 нь хамрагдаад байна. Мөн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс албадын албан хаагчид уг сургалтад хамрагдаад байна.</p>
3.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа болон зөрчлийн үзүүлэлтийг бууруулах.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 1 оронтой тоонд барих Байгууллага албан тушаалтанд улирал бүр өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэх, зөрчил гаргахгүй байх	Байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэх, зөрчил гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг

		<p>тал дээр анхаарч ажиллах чиглэл хүргүүлэх</p> <p>Зөрчил ихээр бүртгэгдэж байгаа хэлтэс албадад зөвлөгөө өгч дахин зөрчил гаргахгүй байх талаар сануулах бусад арга хэмжээг авч ажиллах хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>өдөр тутамд өгч ,улирал бүр чиглэл хүргүүлэн ажиллаж байна. 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 1 цаг 38 минут байна. Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон холдбогдох файл хавсаргаагүй гэх мэт 242 зөрчил бүртгэгдсэн байна. Зөрчил ихээр бүртгэгдэж байгаа байгууллагуудын удирдлагуудад Засаг даргын шуурхай хурлаар хэлэлцүүлэн арга хэмжээ авах тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна.</p>
4.	<p>Өргөдөл гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцон хариуцлага тооцон ажиглах</p>	<p>Өргөдөл гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцсон тухай мэдээллийг албан бичгээр Засаг даргын тамгын газарт ирүүлэх.</p>	<p>Өргөдөл гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн албан хаагчдад арга хэмжээ авах тухай албан бичгийг дэргэдэх хэлтэс албадад улирал бүр хүргүүлж, мөн дахин зөрчил дутагдал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллахыг зөвлөн ажиллаж байна.</p>

5.	<p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ тайланг 7 хоног, сар, улирал бүр гаргаж холбогдох байгууллагуудад танилцуулах, тайлагнах.</p>	<p>Тайлан мэдээг тухай бүр байгууллага, хэлтэс тус бүрээр гарган хүргүүлж үнэлэлт дүгнэлт өгч ажиллах.</p>	<p>Тайлан мэдээг заасан хугацаанд тухай бүр байгууллага, хэлтэс тус бүрээр гарган холбогдох байгууллагуудад хүргүүлж, байгууллагын сайтад байршуулан, үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж байна.</p>
----	---	--	--

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



В.ГОМБОДОРЖ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ,  
САНАЛ ХҮСЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ЧИМЭДДУЛАМ

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

**ТАНИЛЦУУЛГА**

**Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланд хяналт-шинжилгээ хийсэн тухай**

2022 оны 09 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж, ажлын үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, үйл ажиллагааг сайжруулах талаар санал, зөвлөмж өгч, дэмжлэг, үзүүлэх зорилгоор байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Иргэдээс дүүргийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, өргөдөл, гомдлын системийн ашиглалтыг сайжруулах, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, зөрчлийг арилгуулах зорилгоор тайлангийн хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Хяналт шинжилгээний ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалыг ашиглан гүйцэтгэлээ.

**Гурав. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс,  
нэгжүүдэд өргөдөл гомдлыг хүлээн авах хэлбэр**

Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас өргөдөл, гомдлыг дараах хэлбэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. E service аппликейшн
2. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв
3. Хороодод бүртгэж авсан
4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага /цаасаар хүлээн авсан/

5. 1800-1200 дугаарын оператор
6. 11-11 төв
7. Гар утасны аппликейшн зэрэг 7 сувгаар өргөдөл хүсэлтийг тус тус хүлээн авч байна.

**Дөрөв. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, нэгжүүдэд хагас жилийн байдлаар хүлээн авсан нийт өргөдөл, гомдол**

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр 25-ны өдрийн байдлаар нийт 875 өргөдөл хүсэлт хүлээн авсан. Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй гэх мэт 242 зөрчил бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1.

№	Хэлтэс, нэгжүүд	Нийт ирсэн өргөдөл	Бүртгэгдсэн зөрчил	Зөрчлийн эзлэх хувь
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	110	60	55%
2	Санхүү, төрийн сангийн хэлтэс	3	1	33%
3	Хууль, эрх зүйн хэлтэс	53	17	32%
4	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	36	14	39%
5	Нийгмийн хөгжлийн хэлтэс	142	13	9%
6	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	425	104	24%
7	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс	94	8	9%
8	Архивын тасаг	11	12	109%
9	Цэргийн штаб	1	13	1300%
Нийт		875	242	

**НИЙТ БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛИЙГ ТӨРЛӨӨР НЬ АНГИЛЖ ХАРУУЛБАЛ**

Хүснэгт 2.

Д/д	Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Хувь
1	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	118	48.8%
2	Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	-	
3	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо	97	40.1%
4	Холбогдох файл хавсаргаагүй зөрчил	1	0.4%
5	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	26	10.7%
Нийт		242	100%



Нийт 242 зөрчил бүртгэгдсэнээс хамгийн олон буюу өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил 118 /48.8%/, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо 97 /40.1%/, өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил 26 /10.7%/ байна.

### Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Нийт 875 өргөдлөөс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 818, судлагдаж байгаа 51 өргөдөл хүсэлт байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 6 өргөдөл хүсэлт байна бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 94,1 хувьтай байна. Үүнийг графикаар харуулбал.

График 1.




2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 1 цаг 38 минут байна.

### Тав. Зөвлөмж

1. UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд системийг үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэж хэвших,
2. UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд системийг байгууллага, нэгжийн удирдлагууд өдөр бүр шалгаж, ирсэн өргөдлийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд тухайн өдөрт нь багтаан шилжүүлж хэвших,
3. Өргөдөл, гомдлын дагуу шаардлагатай үйл ажиллагаа зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх шаардлагатай бол заавал явцын тэмдэглэл хөтөлж ажиллах,
4. Дүүргийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг одоо байгаагаас багасгах боломж байгаа тул хэлтэс, нэгжүүдийн удирдлага, албан хаагчид санаачилгатай ажиллаж, хугацаа шаардахгүй өргөдөл, хүсэлтүүдийг тэр даруй шийдвэрлэх,

5. Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд зөрчлийн эзлэх хувь хамгийн өндөр байгаа албан тушаалтнуудад зөрчил арилгах талаар сургалт, зөвлөгөө өгч ажиллах,
6. Өргөдөл, гомдлын ихэнх хувийг эзэлж байгаа асуудлаар хариуцсан байгууллага, нэгжүүд хаана ямар асуудал болохгүй байгаа тал дээр санал, төлөвлөгөө боловсруулж анхаарч ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА



Н.ЭНХБОЛД

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ИРГЭНИЙ ОРОЛЦОО ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

*J. Niyamdorj*

Г.НЯМДОРЖ